

Хэвлэл мэдээлэл: Бид зохицуулах уу, Ц.Нямдорж зохицуулах уу?

(Өөрийн зохицуулалтаас хэн хожих вэ?)

Ц.Онон, сэтгүүлч

Сэтгүүлчийн мэргэжлийн алдааг ашиг сонирхлын өрчилтэй засаг захиргаа биш мэргэжил нэгтгөд нь шүүснээр өөрийн зохицуулалт сэтгүүлчийн хараат бус байх эрхийг хамгаалдаг. Цагт хавчигдах, мэдээг баталгаажуулах, мэдээлэлд нэвтрэх эрх дутах, санхүүгийн хангалтгүй эх үүсвэр, үг хэллэгийн ялгаа, мэдээллийн эх сурвалжаа хамгаалах, технологийн хоцрогдол гээд редакцийн гал тогооны зовлонгөвжөн мэргэжлийн сэтгүүлчид л ойлгоно.

Тиймээс “чоно цатгалан хоньрун байх хувилбар” буюу шүүхийн альтернатив хувилбар нь хэвлэлийн өөрийн зохицуулалт болоод байна. Сэтгүүлч аль нэг дүүргийн цагдаа шүүхийн хаалга сахиж¹, Ц.Нямдорж² сайдаар цүүлгэх биш, мэргэжил нэгт өгдөөсөө бүрдсэн Хэвлэлийн зөвлөлөөр шүүлгэж хамтын шийдвэрийг сонсох нь шүүхээс ял авснаас дээр билээ. Хэвлэл Засгийн газрыг хянах “хоточ нохойн өөрийн үүргээ Засгийн газрын зүгээс хамгийн бага хяналттай байж л гүйцэтгэж чадна.

“Хэвлэл мэдээллийн хэрэгслийн өөрөө удирдах ёсны норматив үндэс нь хуульд “найдах” бус харьцангуйн тогтоосон олон нийт, заншлын хийгээд ёс зүйн хэм хэмжээ байх учиртай. Түүний чухлыг Монголд Үндэсний бөхийн дүрэм журмаар ч төсөөлөн ойлгож болох юм. Бөхийн барилдааныг яаж зохицуулахыг хуульчилдаггүй. Хууль бол хэвлэл мэдээллийн хэрэгслийн “гадаад” харилцаанд хамаарахаас бус “дотоод” харилцаанд хутгалдан орох ёсгүй. Харин түүнийрсдийн тогтоосон заншил, ёс зүйн гэх “олон нийтийн” хэм хэмжээгээр зохицуулах нь бие даасан байдлаа хангах гол механизм болно” гэж хуульч Б.Чимид гуай нэгэнтээ саналаа хэлж билээ.

Манай цүх үнэн мөнийг олдоггүй, зөвхөн гэм буруутай эсэхийг тогтоодгийн адил Хэвлэлийн зөвлөл нь тухайн нийтлэл бичсэн сурвалжлагчийг сэтгүүлчийн ёс зүйн зарчим зөрчсөн эсэхийг л тогтооно. Товчхондоо сэтгүүлчийг шүүхэд очихоос вакцинжуулж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн өөрийн зохицуулалт гэж хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллагсад, редакциудын хамтдаа сайн дураараа баталсан зарчмыг олон нийтэд нээлттэй мөрдүүлэх мэргэжлийн нийгэмлэг юм. Сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх байгууллага нь Хэвлэлийн ёс зүйн зөвлөл³ юм.

Хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгсэлтөө хариуцлага үүрч, түүгээр редакцийн бие даасан байдлаа бүрэн хангана гэсэн үг. Уншигч үзэгчид өөрийн үйл ажиллагаанд хариуцлагатай ханддаг сонинд ТВ-д илүү итгэдэг.

Хэвлэлийн өөрийн зохицуулалтаар дэмжүүлсэн чанартай сэтгүүл зүй нь эрх чөлөө ба хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус үйл ажиллагааны нэмэлт баталгаа болох юм.

¹ Эрүүгийн хуулийн 111-р зүйл ангиар 4 хэн жилийн дотор 18 хүн ял эдэлсэн судалгаа гарсан. Нэгхэн жилийн дотор эрүүгийн хуулийн заалтаас үүдэн 6 сэтгүүлч шүүхийн тогтоол уншуулаад байна. Сэтгүүлч бусдын эрх ашгийг хохироожээ. Үлбөрийг нь өөрийнхөө эрх чөлөөгөөр хийж байна. Ардчилсан зарчимд нийцэж байна уу? Нийцэж байна. Цэг.

² Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржийн нэрийг энд “эрх баригчид” гэсэн ёгт утгаар орлуулсан юм шүү. 2000-2005 онд үүнийг Хууль зүй дот оод хэргийн сайд байх үед ХЗДХЯ хэд хэдэн сонинг хаах арга хэмжээ авч, Эрүүгийн хуульд сэтгүүлчдийн зүрхэнд орсон 2 заалтыг нэмж оруулсан билээ.

³ Хэвлэлийн Консул ч гэж нэрлэдэг энэ сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллага дэлхийн 54 улсад ажилладаг. Хэвлэлийн Консулын тухай мэдээллийг www.media-accountability.org, www.wanewsCouncil.org вэбсайтуудаас үзнэ үү. Хэвлэлийн Консул нь Сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мөрдүүлэх, нөгөөтэйгүүр сэтгүүлчдийг хамгаалах, сэтгүүлчийн нэрээр хаягласан гомдлыг шүүхийн өмнөх шатанд эвлэрүүлэх журмаар шийддэг байгууллага.

Эрх ба үүргийг баланслах нь

Хэвлэлийн өөрийн зохицуулалт бол том бодлого их орон зайд чанартай сэтгүүл зүйд байх ёстой нэг тогтолцоо юм. Яг л АН бол консерватив, МАХН бол социал демократ нам байх ёстой гэдэг шиг манай нийгэмд нэгтэй байрандаа байх ёстой ойлголт, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн зарчим, түүнийг мөрдүүлэх байгууллага, хэвлэлийг хараат бус хариуцлагатай байлгах систем билээ.

Эрх чөлөө, хариуцлага нэг зоосны хоёр тал юм. Хэвлэлийн эрх чөлөөг эдлэхтэй зэрэгцэж нийгмийн өмнө хүлээх хариуцлага хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сонинд оногддог бөгөөд сэтгүүлчид мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөх ёстойг сэтгүүлчид ойлгодог. Хэрэв хэвлэл мэдээллийн хэрэгсэл хариуцлагагүй хандвал олон түмний дэмжлэгийг алдаж, улмаар дөрөв дэх засаглал гэж хичнээн чанга хашгираад ч үр дүн нь хоосон талд цуурай мэлдэнэ. Хэвлэл хүмүүст таалагдаж байж захиалга, сурталчилгааны их ашиг олно. Чухам энэ ашгийн өлөө хэвлэл үнэн зөв, бодитой, дундыг баримталсан, сонирхолтой мэдээллийг үгээнэ. Үүнийг дагаад ёс зүйн асуудал дагалдана. Ёс зүйтэй байж л олон түмний итгэлийг байнга хүлээнэ. “Чөлөөт хэвлэл зөвхөн олон түмнээс, өөрөөр хэлбэл зах зээлээсээ хамааралтай.”⁴

Сонин хэвлэлийн алдааг тэвчин уучилдаг байх үр дүнд өрнийн чөлөөт хэвлэл өнөөгийн сонгодог утгаа олон төлөвшиж, ардчилал гэдэгтэй аналог болон зөвшөөрөгдсөн юм. Гэхдээ уучлал гэдгийг хуулийн хариуцлагаас дархлан өлөөлөх гэдэг шууд утгаар нь бус, харин сэтгүүлчийн алдааг төсвийн мөнгө туусан луйварчны үйлдлээс ялгаатай авч үзсээр ирсэн практик гэж ойлгохыг хүсч байна.⁵

Уг нь сэтгүүлчдийн баримтлах ёс зүйн зарчим, код чамлахааргүй байдаг ч хэрэгжилтэд нь хяналт тавьдаг, хариуцлага тооцдог механизм өнөө хэр бүрдээгүй байгаа. Тухайлбал, Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл, Монголын Чөлөөт Сонинуудын Холбоо, МОНЦАМЭ болон Ийгл ТВ-ийн Мэдээллийн алба зэрэг эвлэл, холбоо, байгууллагууд өөр өөрийн ёс зүйн дүрмүүдийг баталсан. Гэсэн хэдий ч дүрэм журмаа сайн мөрдөж буйг сайшаадаг, алдаа дутагдал гаргасанд хэрхэн хариуцлага тооцох тухай дүрэм заалт байсангүй.⁶

Энэ жил 4 дүгээр сарын 24-нд МСНЭ-ээс Ёс зүйн хороо байгуулах талаар хэвлэлийн бага хурал хийсний маргаашаасаа л өдөр тутмын хэвлэлүүдээр баахан хардсан нийтлэлүүд дагуулсан билээ.

Хардлага

Энэ зарын тухай тал талаас нь бичжээ. “Яаж ч бодсон ард нь тодорхой зорилго бүхий эрх мэдэлтэн, улс төрийн ашиг хонжоо хайгч байгаа нь харагдаад байна. Учир нь сэтгүүлчдийнх нь эрх ашгийг хамгаалах нэрээр эрхлэгчдийнх нь амыг үдэх зорилго нуугдаж байгаа нь хэвлэлийн хурлын өнгө аясаас анзаарагдсан”⁷ гэж “Өдрийн сонин” сонин бичсэн бол “Арга мухардсан ч өрөөс дэмжлэг авч болохгүй. Тэгэхгүй аваас улстөрчдөөс хамааралтай болох нь тодорхой. Хэвлэлийн эрх чөлөөгтэй орнуудын туршлагаас харахад Хэвлэлийн Консулаа хэвлэл мэдээллийн эзэд өөрсдөө санхүүжүүлдэг нь бие даасан байдлаа хадгалахад чухал нөлөө үзүүлдэг байна. Тэгэхээр Хэвлэлийн Консулын удирдах үйлдэхүүнд Монголын өдөр тутмын сонинуудын холбоо, Монголын сонин холбоо,

⁴ Б.Баабар “Хэвлэлд ээлтэй хүн” 2004.05.03

⁵ Шар Хэвлэлтэй Хийх Тэмцлийн Үйлдлийн Дараалал, Д.Гантуг, 2002

⁶ Монголын үйлчдийн мэргэжлийн түгээмэл алдаа

Г.Гүнжидмаа

/Хэвлэлийн

Хүрээлэн/<http://www.forum.mn/contents.php?coid=1455&cid=149>

⁷ “Хэвлэлийн ёс зүйн консул” гэж хийн ард хэн байна вэ? Д.Мөнгөндалай Өдрийн Сонин 2008/04/29

телевизүүдийн холбоо, МСНЭ-ээс зайлшгүй төлөөлөгч багтсан байх нь сэтгүүлчдийн жинхэнэ эрх ашиг юм.⁸” гэж “Зууны шуудан” бичжээ.

“Өдөр тутмын, долоо, арав хоногийн сонин, радио, телевизнүүд нийлүүлж ёс зүйн консулаа байгуулаад, түүнийгээ мэргэжлийн төвшинд ажиллуулна гэхэд сэтгэл санааны бэлэн байдал, мэдлэг боловсрол, соёл байна уу гэдэгт би эргэлзэж байна. Хэн нэгэн донор байгууллага гарч ирээд энэ мөнгийг ав гэдэг юм гэхэд нэг хэсэгтээ явах л байх. Тэгвэл мөнгө дуусахад л тэр байгууллагын үйл ажиллагаа зогсоно⁹” гэж Хэвлэлийн хүрээлэн үзэж байх шиг. Мөн “хариуцлагатай сэтгүүл зүйн төлөө сэтгүүлчийг хуулиас өмнө ёс зүйн хариуцлага хүлээлгэх үүрэг бүхий Хэвлэлийн Консул байгуулах хэрэгцээ үгүйлэгдсээр байна¹⁰” гэж нэмж хэлжээ.

“Тэд одоо Хэвлэлийн консул байгуулах юм гэнэ. Тэгээд хэвлэл мэдээллийн эздийг шvvнэ гэнэ. Ж.Мягмарсүрэн, Б.Ганболд, З.Алтай, А.Авирмэд нарын чөлөөт хэвлэлийн эцгүүдийг хэдэн шар сонины эрхлэгч дуртай цагтаа дуудаж байцаахыг өрөөдөж байна. Ёстой тэд дуудна ч байх, бид очно ч байх.¹¹” гэж “Өдрийн сонин” бухимджээ.

Эдгээр шүүмжлэлт нийтлэлүүдийн үндсэн агуулга нь Хэвлэлийн зөвлөл хэрэггүй гэсэн биш харин үүсгэн байгуулагчдын нэр хүнд тааруу, ирээдүйн Хэвлэлийн зөвлөлийн бүтцэд сэтгэл зовж байгаагаа илэрхийлжээ.

Өөрсдийн төлөө, өргөн түмний төлөө, хvний төлөө вээл бодлоо өргөн дэлгэр илэрхийлэн дэмжлэг авах замаар, тасгийн газар тvvний байгууллага албан тушаалтнуудын вйл ажиллагаанд юлөөлөх хvчтэй хэрэглvvр нь хэвлэл мэдээлэл-дөрөв дэх эрх мэдэл. Харин манайхан "засаглал" хэмээн андуурч, өр тvvний байгууллагын нэг хэсэг мэт буюу аанай л бусдыг засагладаг, захирдаг, дэглэдэг хvч хэрэгсэл мэт ойлгуулан тэгснээр ард олноос внди йрэхэд хvргэж болзошгvй байна. Юуны чинь засаглах вэ? Харин засагрийг олны мэдээллийн хvчээр л хянаж ариусгах онцгой эрх мэдэл байхгvй юу!¹²

Хэвлэлийн ёс зvйн холбогдолтой маргааныг урьдчилан хянан шийдвэрлэдэг хендлөнгийн механизм болох Хэвлэлийн ёс зvйн зөвлөл ийнхүү олон сонирхлынөрвнил дунд дуншиж байна. Хэвлэлийн гүтгэлгийн хэргийг шийдвэрлэж байх цоо шинэ чиг хандлагыг тогтоож байна.

Хэвлэлийн Зөвлөл хэрхэн ажиллах вэ?

Хэдийгээр иргэн вн нэр төрөө сэргээлгэхээр шүүхийн байгууллагад хандах эрх нь нээлттэй боловч ийнв шүүхэд нэхэмжлэл гаргахаасаа өмнө Хэвлэлийн Зөвлөлд хандаж, тухайн сэтгүүлч сэтгүүлчийн ёс зүйгээ зөрчсөн эсэх талаар мэргэжлийн дүгнэлт гаргуулан авдаг практик дэлхийн олон оронд бий. Бараг дийлэнх тохиолдолд хэвлэл болон иргэний хооронд үүссэн гүтгэлгийн холбогдолтой маргаан нь Хэвлэлийн Зөвлөлийн шийдвэрээр эцэс болж, сонин хэвлэл нь залруулга хэвлэн, уучлал гуйдаг. Гутаагдсан нэрөр шүүхийн шийдвэрийн дагуу сонины газраас мөнгөн төлбөр гаргуулснаар л сэргэдэг гэж ойлгох нь өрөөсгөл тул энэ асуудал заавал шүүхийн байгууллагаар шийдэгддэг байх албагүй гэсэн санааүүний цаана байдаг. Хэвлэлийн Зөвлөл аливаа уншигчийн зүгээс гаргасан гомдол, маргааныг хянан үзээд, сэтгүүлч ёс зүйгээ зөрчсөн гэсэн дүгнэлт гаргавал тухайн сонины газар нь анхны ташаа

⁸ Хэвлэлийн консулыг “хадны мангаа” болгомооргүй байна. Б.Цогнэмэх. Зууны Шуудан 2008/05/06

⁹ М.Мөнхмандах: Сэтгүүлийн давуу чанар нь универсал байх ёстой. “Цаг төр” сэтгүүл. 2008. <http://tsagtur.news.mn/content/2917.shtml>

¹⁰ “Авлигатай тэмцэхэд чөлөөт хэвлэлийн үүрэг” |Г.Цогтбаатар|2008-Mar-25, <http://tsogtoo.blogmn.net/13031/>

¹¹ Хэвлэл нийтлэх эрх чөлөөн дээр минь Ерөнхийлөгч та бvн гишгэ. Л.Мөнхбаясгалан. <http://publish.news.mn/show?id=314>

¹² Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх болон хэвлэл мэдээллийн эрх чөлөө” Б.Чимид - Монгол Улсын гавъяат хуульч, доктор (Ph.D), профессор <http://www.globelinter.org.mn/index.php?cmd=Content&id=300&menuid=60>

мэдээлэл тараасантай яг адил арга байдлаар залруулга, уучлал хэвлэх үүрэгтэй болдог ба тодорхой хэмжээний мөнгөн торгууль төлдөг. Энэ торгууль нь Хэвлэлийн Зөвлөлийн санхүүжилтийн нэг хэсэг болдог. Хэвлэлийн Зөвлөл амжилттай ажиллах нэг гол хүчин зүйл бол хэвлэлийн салбарт ажиллаж буй бүх хүн сэтгүүлчийн ёс зүйн баримт бичгийг даган мөрдөж байхаа батлан, гарын үсгээ зурсан байх явдал юм.¹³

Харин хэвлэлийн эсрэг дэгдсэн маргааныг Хэвлэлийн Зөвлөл анхлан шийдвэрлээд түүгээрээ зохицуулж дуусвал сайн хэрэг боловч хэрэв түүний шийдвэрийг нэхэмжлэгч буюу гомдогч эс эвшөөрвөл шүүхэд хандах эрх нь хэвээр үлдэнэ. Энэ бол иргэдийн Үндсэн хуулийн эрх юм.¹⁴ Үүнээс үүдээд шүүхэд Хэвлэлийн зөвлөлийн шийдвэрийг хэрэглэх үү, үгүй юу гэсэн асуулт гарч ирнэ.

2007 онд “Хэвлэлийн өөрийгөө зохицуулах механизм буюу Хэвлэлийн Консулуудыг харьцуулсан судалгааг”¹⁵ Дани, Их Британи, Недерланд, Швед, Босни-Герцеговинагийн Хэвлэлийн Консулын жишээгээр судлаад дараах зөвлөмжийг бичсэн юм:

- Үр дүнтэй ажиллах Хэвлэлийн Консул хэвлэл мэдээллийн эсрэг үүсэх эрүүгийн болон иргэний хэргийг цөөлнө. Шүүхийн өмнөх шатанд сэтгүүлч ба нэхэмжлэгчийг эвлэрүүлэх журмаар хэргийг шийдсэнээр шүүхээр шийтгэгдэх сэтгүүлчдийн тоог цөөлнө.
- Хэвлэлийн Консулынү б тэц нь хэвлэл мэдээллийн эзэд, сэтгүүлчид, эрхлэгч нарын корпорацичлагдсан хольц байна. Хэвлэлийн Консулын үрэлдэхүүнд хэвлэл мэдээллийн эзэд, сэтгүүлчид, эрхлэгч нар болон олон нийтийн төлөөллийг ижил тоотой оруулж, шийдвэр гаргах тэнцвэрийг хадгалах нийтэй. Хэвлэлийн Консулыг шүүгчээр даргалуулах нь зүйтэй. Хэвлэлийн Консулын гишүүд орон тооны бус, харин нарийн бичгийн дарга нар орон тооны байх нь зүйтэй.
- Хэвлэл мэдээллийн салбар Консулын үйл ажиллагааны зардлыг бүрэн санхүүжүүлж байна.
- Консулын үйл ажиллагааны төсвийг батлах бүтэц тусдаа байх нь санхүүгийн сахилга бат алдагдахаас сэргийлж байна
- Консулын үйл ажиллагааны стандартыг нь үнэлэх, ёс зүйн дүрэм шинэчлэх бүтэц нь Консулаас тусдаа байна.
- Хэвлэлийн Консулуудын үйл ажиллагаа тунгалаг, жил бүрийн тайлан нь олон нийтэд ил тод байна.
- Хэвлэлийн Консулын мөрдөх сэтгүүлчийн ёс зүйн дүрмийг нийтээр хүлээн зөвшөөрсөн байх
- Хэвлэлийн Консулын талаар хуулинд шууд заалт орох шаардлагагүй.
- Консулын шийтгэл нь шийдвэрийг олон нийтэд мэдээлэх, залруулга ба уучлал хүссэн нийтлэл нийтлэхээс хэтрэх ёсгүй. Залруулгын хэмжээ, нүүрний байрлалыг Консул тогтоох нь зүйтэй
- Хэвлэл мэдээллийн хаягласан гомдлыг Консул үнэ төлбөргүй барагдуулах нь зүйтэй.
- Консулын санхүүжилтэнд гадаадын олон улсын байгууллагаас дэмжлэг авч болно
- Консул мөрдөн шалгах эрхгүй

Гарц: Зөвшилцөл

¹³ Шар Хэвлэлтэй Хийх Тэмцлийн Үйлдлийн Дараалал. Д.Гантуг. 2002

¹⁴ Монгол Улсын Үндсэн хууль, 16-гийн 14

¹⁵ “Хэвлэлийн өөрийгөө зохицуулах механизм буюу Хэвлэлийн Консулуудыг харьцуулсан судалгаа: Дани, Их Британи, Недерланд, Швед, Босни-Герцеговинагийн Хэвлэлийн Консулын жишээ” Ц.Онон, Нээлттэй Нийгэм Форум, 2007

Сэтгүүлчдийг шүүх цагдаад хүргэлгүй дархлаажуулах, мэргэжлийн сэтгүүл зүйн стандартыг мөрдүүлснээр хэвлэл мэдээллийн нэр хүндийг өргөх нь Хэвлэлийн өвлөлийн зорилго билээ. Үүний төлөө сонин ТВ-үүдийн эвсэл холбоо, сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллагууд нэгдсэн эрх ашгаа харж нэгдэж үг хэлээ ололцож, санхүү босгож, ашиг сонирхлоо, сэтгүүлчдээ хамгаалж чадна гэдэгт итгэж байна.

Хэвлэлийн өвлөлийн амжилт олох зайлшгүй нөхцөл нь Хэвлэлийн зөвлөл нэр хүндтэй байх явдал.

Мөнгө бүрэн ноёлсон, эрх зүйн орчин таатай бус¹⁶ өнөөгийн нөхцөлд мэргэжлийн сэтгүүл зүй амьд байгаа г харуулъя, удахгүй байгуулагдах Хэвлэлийн ёс зүйн зөвлөлийг ойлгож дэмжээсэй гэж бодож энэ илтгэлийг бичлээ. Мэдээ жөөцөлдөн ямагт яарч явдаг өдөр тутмын тойргоосоо нэг удаа холдоод хараат бус ажиглагчдын үгийг сонсож, өөрийгөө тольдож санаа аваасай гэж бид мэргэжил нэгтэй нөхөддөө хандаж байна.

“XIX зүйл ба эрх зүйн орчин” дугуй ширээний ярилцлага
2008.12.08

¹⁶ Америкт сонины нийтлэлийн агуулгаа үүдэлтэй гүтгэлгийн маргааныг иргэний хуулийн сэдэв болгохоос бус эрүүгийн хуулиар шийддэггүй. Буруудсан сэтгүүлч, хэвлэлд санхүүгийн хариуцлага хүлээлгэхээс өөрөөр хорьж цагдах хуулийн заалт Америкт байдаггүй. Гэмгүй нэгэн иргэнийг өчүүхэн ялаа мэт сонингоор "алсан" бол тухайн сэтгүүлч шоронд орох биш, харин халаасаа сэгсрүүлээд гудамжинд гардаг жамтай.